



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/384

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Засаг дарга Батсуурийн Дүгэржавын ивээл дор зохион байгуулагдах “Зуун буудалт даамны нээлттэй тэмцээн”-ий зардал 1476900 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрхи арга хэмжээний зардалд 1476900 төгрөг /Нэг сая дөрвөн зуун далан зургаан мянга есөн зуу/-ийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.17 дахь “Спортын аварга” хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДУГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2019 оны  
06 дугаар сарын 19-ний өдрийн  
А/384 дүгээр захирамжийн хавсралт



“ЗУУН БУУДАЛТ ДААМНЫ НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭН”-ИЙ ЗАРДАЛ

дд	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг брийн үнэ	Нийт дүн	Тайлбар
1	Аннонс	1 /3*4/	120000	120000	
2	Өргөмжлөл	12	2000	24000	
3	Медаль	6	8000	48000	
4	1 дүгээр байр	2	100000	200000	
5	2 дугаар байр	2	80000	160000	
6	3 дугаар байр	3	60000	120000	
7	Тусгай байр	4	20000	80000	
8	Хамгийн залуу	1	10000	10000	
9	Хамгийн ахмад	1	10000	10000	
10	Шүүгчийн хөлс	2	20000	40000	
11	ТВ зар	2 /6 өдөр/	30000	60000	
12	Хөтөлбөр зар	47	200	9400	
13	Даамны хөлөг	20	6000	120000	
14	Хоолны зардал	6	-	475500	
	Нийт дүн			1476900	

--oOo--